



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

Тарифт өөрчлөлт оруулах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Тариф батлах тухай” 22 дугаар тогтоолын 1 дэх хэсгийн “худалдах дулааны тариф (НӨАТ-гүй)-ыг 6,605.0 төгрөг/ГЖ-иар” гэснийг “худалдах дулааны энергийн тариф (НӨАТ-гүй)-ыг 4,625.0 төгрөг/ГЖ-иар, чадлын тариф (НӨАТ-гүй)-ыг 491,122.0 мянган төгрөг/сараар” гэж өөрчилсүгэй.

2. Энэхүү өөрчлөгдсөн тарифыг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд мөрдөж ажиллахыг “Амгалан дулааны станц” ТӨХК (Ш.Баянмөнх), “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК (Г.Баярсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Г.Эрхэмбаяр)-нд даалгасугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ

Э.САМДАН

ЗОХИЦУУЛАГЧ

Ц.НОРОВЖАМЦ